

ДҮҮРГИЙН ЭРҮҮ, ИРГЭНИЙ ХЭРГИЙН ХЯЛБАР АЖИЛЛАГААНЫ АНХАН ШАТНЫ ТОЙРГИЙН ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗАР

	Зөвлөлт	Биелэлт	Хэрэгжилтийн хувь
Нэг .Захиргаа, удирдлагын чиглэлээр:			
1	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, шүүхийн Тамгын газруудын ажлыг уялдаа холбоог хангахад ашиглаж байгаа удирдлагын цахим /вайбер/ групп байршуулсан мэдээ, мэдээлэл, үүрэг, чиглэлтэй тухай бүх шуурхай танилцаж, холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж, эргэх холбоотой ажиллах	Тус шүүхийн тамгын газар нь тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс байршуулсан мэдээлэл хүргэх тухай 32, судалгаа авах тухай 43 ажлыг хугацаанд нь гүйцэтгэн хүргүүлж, шүүгч, ажилтны нэгдсэн группт тухай бүр мэдээллийг хүргэж ажиллалаа.	100
2	Шүүх, шүүхийн Тамгын газрын хэвлэмэл хуудсыг хянагдсан загварт заасан хэмжээ, үсгийн фонд, өнгөний кодыг ягштал баримтлан алдаагүй хэвлүүлж хэрэглэж хэвших	Шүүх байгуулах тухай хуулийн шинэчилсэн найруулга, архив, албан хэрэг хөтлөлтийн хууль тогтоомжид нийцүүлэн тус шүүхийн хэвлэмэл хуудасны эх загварыг Архивын ерөнхий газраар хянуулж, баталгаажуулсан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 15-ний өдрийн 03/1953 дугаартай албан бичгээр хүргүүлсэн Архивын ерөнхий газрын 2024.12.10-ны өдрийн 212 бүртгэлийн дугаартай, Улсын байцаагчийн №48 дугаартай үндэсний бичиг болон кирилл бичгийн 16 нэр төрлийн хэвлэмэл хуудсыг батлуулан 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаандаа ашиглаж байна. Хэвлэмэл хуудсыг хянагдсан загварт заасан хэмжээ, үсгийн фонд, өнгөний кодыг баримталж Шүүхийн ерөнхий зөвлөлийн захиргаа удирдлагын газрын дарга Д.Санжрагчаад хянуулан алдаагүй хэвлүүлэхээр "Тоонот Принт ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж байна. Тус шүүхийн тамгын газрын даргын А/2 тоот "Шүүхийн хэвлэмэл хуудас хадгалах, олгох, хяналт тавих ажилтан томилох" тухай тушаалаар тус шүүхийн хэвлэмэл хуудас хадгалах, олгох, хяналт тавих ажилтнаар Б.Амарбаясгалан, дээрх ажиллагаанд хяналт тавьж ажиллахаар хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Т. Цэрэнчимэд нарыг томилон ажиллаж байна.	100
3	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс шинээр болон шинэчлэн баталсан дүрэм, журмыг тухай бүр сайтар судалж, байнгын хяналтад авч, мөрдөж ажиллах шүүхийн иргэдийн төлөөлөгчийн тангарагийн хуучин хуудас хэрэглэсэн, 60 нас хүрсэн иргэнийг шүүх хуралдаанд оролцуулсан зэрэг хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй байх	Тайлант онд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс батласан 6 журам, 12 албан бичигтэй танилцан үйл ажиллагаандаа ашиглаж байна. Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх иргэний хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэргийн хөдөлгөөний түр аргачлал батлах тухай, Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн шүүгчийн 2025 оны ажлын зохист ачаалал тогтоох тухай, Шүүгчийн хувийн хэрэг хөтлөх, Шүүхийн үйлчилгээний стандарт батлах тухай, Шүүхийн хэргийн индексийн журмыг баримтлан ажиллаж байна. Тус шүүхэд иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох зохицуулалтгүй болно.	100
4	"Цахим шүүх – 2.0" цөм системийг тухайн шүүх, шүүхийн Тамгын газарт нэвтрүүлэх хүний нөөцийн хуваарилалтыг оновчтой зохион байгуулж, ажлын үр дүнд хяналт тавьж ажиллах, илүү цагаар ажилласан албан хаагчдын ажилласан цагийг бодитой тооцох, тэднийг нөхөн амраах, шагнал, урамшуулалд эхний ээлжинд тодорхойлох, илүү цагийн хөлсийг зөв тооцож олгох зэрэг арга хэмжээг батлагдсан төсөв, хуулийн хүрээнд авч хэрэгжүүлэх	Цахим шүүх-2.0 системийн хүрээнд зөрчлийн, таслан сэргийлэх арга хэмжээний системийн туршин нэвтрүүлэлт явуулах шүүхээр тус шүүх шалгарсан. Системийн ажлын хэсэгт 20 шүүгч, ажилтан багтаж таслан сэргийлэх арга хэмжээний 297, зөрчлийн хэргийн 118, иргэний хэргийн 37 удаагийн санал өгч 2 сарын хугацаанд туршин нэвтрүүлэлтэд оролцсон. Илүү цагаар ажилласан ажилтанд олгох хөлс төсөвт хүрэлцээгүй Шүүхийн ерөнхий зөвлөлөөс боломжгүй гэсэн тул нөхөн амраав.	100
5	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг 2025 онд шинэчлэх ажилд хариуцлагатай, шуурхай хандаж, нутгийн захиргааны байгууллагатай хамтран нэрсийн жагсаалтыг алдаагүй гаргахад онцгой анхаарах	Тус шүүхэд хамаарахгүй	100
6	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд оролцохын өмнө санал, дүгнэлт хэрхэн бичих талаар арга зүйн зөвлөгөөг тухай бүр өгч байх	Тус шүүхэд хамаарахгүй	100
7	Шүүх хуралдаанд оролцохоор сонгогдсон иргэдийн төлөөлөгчид чөлөө олгох талаар ажил олгогчид нь урьдчилан мэдэгдэх ажлыг хариуцлагатай хийж байх;	Тус шүүхэд хамаарахгүй	100
8	Шүүхийн иргэдийн төлөөлөгчийг шүүх хуралдаанд цахимаар оролцуулах бэлтгэлийг тухай бүр сайтар хангаж байх, орон нутгийн иргэдийг цахимаар оролцуулахад аймаг, сумын Засаг даргын Тамгын газрын танхим, тоног төхөөрөмжийг ашиглахад анхаарах	Тус шүүхэд хамаарахгүй	100
9	Иргэдийн төлөөлөгч нарт зориулсан сургалтыг зохион байгуулах, гарын авлагаар хангах	Тус шүүхэд хамаарахгүй	100
10	Шүүхийн эвлэрүүлэн зуучлалын системийн ашиглалтад шүүхийн Тамгын газраас хяналт тавих	Шүүхийн эвлэрүүлэн зуучлалын систем ашиглалтад 14 хоногт нэг удаа хяналт тавьж, 2 эвлэрүүлэн зуучлагчийн туслахад анхааруулга өгч ажиллав. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар 2881 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн бөгөөд үүрэн телефоны төлбөр гаргуулах тухай 500 нэхэмжлэлийг богино хугацаанд, алдаа зөрчилгүй хүлээн авахад 6 ажилтныг хамруулав. Систем ашиглалт хэвийн, алдаа зөрчилгүй явагдаж байна.	100
11	Нийт шүүгчийн 3 дугаар чуулганы мэдээллийг шүүгч нарт хүргэх, шүүгч нарыг чуулганд оролцуулах ажилд хамтран ажиллах	Тус шүүхийн шүүгч Х.Оюунжаргал Нийт шүүгчийн чуулган зохион байгуулах ажлын хэсгийн гишүүнээр томилогдсон. 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд чуулганы хөтөлбөр, мандат тараах ажлыг зохион байгуулж мэдээлэл хүргэх тухай 5 арга хэмжээг нийт 41 шүүгчид танилцуулсан. Шүүхийн нүүр хуудсанд 2 удаагийн видео шторкийг нийтэд мэдээлэв.	100

12	Шүүхийн шуудангийн үйлчилгээний гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, төлбөр тооцоог гүйцэтгэлтэй нь тулган хийх, гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх 2025 оны 6 дугаар сарын 30, 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлэх	"Монгол Шуудан" ХК-тай 2025 оны 01 дүгээр сарын 02-ний өдөр №14/25 дугаартай Шуудангийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Хагас жилийн санхүүгийн тайланд " Монгол шуудан" ХК-тай авлага, өглөгийн тооцоо нийлсэн акт үйлдэж хавсаргасан. Гэрээний хэрэгжилт хангалтгүй байгаа талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичиг хүргүүлж, энэ талаар Гүйцэтгэх нарийн бичгийн дарга Б.Эрдэнэтүлгатай уулзалт явуулсан. Шуудангийн үйл ажиллагаанаас хариуцагч дуудан ирүүлэх ажиллагааг хороодын хэсгийн ахлагчтай хамтран ажиллах нь үр дүнтэй талаар 3 удаагийн санал хүргүүлсэн. Тайланг 2025 оны 6 дугаар сарын 25-ны өдөр хүргүүлсэн.	100
Хоёр.Цахим хөгжил, мэдээллийн технологийн удирдлагын чиглэлээр:			
1	Шүүхийн захиргааны үйл ажиллагааны ERP системийн ашиглалтыг нэмэгдүүлж, жигдрүүлэх: Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын систем (ERP)-ийн ашиглалтыг нэмэгдүүлэх хүрээнд захиргааны албан хаагчдадаа эрх үүсгэж, үйл ажиллагаандаа ашиглах боломжууд /Хүний нөөцийн удирдлага, цаг бүртгэл, хурал, үүрэг даалгавар, ер, e-chat гэх мэт/-ыг нэмэгдүүлэхэд анхаарч, албан бичиг боловсруулалтыг цахимд шилжүүлэн ажиллах	Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын систем (ERP)-д 144 албан бичиг хүлээн авч 144 хариуг хугацаанд нь хүлээлгэн өгсөн байна. Албан бичиг боловсруулалтаар 11, файлаар илгээсэн 10 баримт хүргэгдсэн байна. Шүүхийн захиргааны 145 ажилтанд эрх үүсгэж, гарын авлага тараан ажиллав. Системийн ажиллагаа 2025 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн байдлаар жигдэрсэн. Цаг бүртгэл, албан бичиг хүлээн авах, хариу өгөх ажиллагаа хэвийн явагдаж байна.	100
2	Нэгдсэн системийн ашиглалт, алдаа зөрчлийг багасгах: Системд гарсан алдаа зөрчлийг залруулах асуудлаар анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газраас 2022 онд 1634, 2023 онд 1839 тухай цахим хувьд ирүүлсэнээс 20 хувь нь системийн алдаа, 80 хувь нь хэрэглэгчийн алдаа байна. Эрүү, иргэн, захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийн ашиглалтын талаарх сургалт, мэдээллийг шинээр томилогдсон болон алдаа зөрчил их гаргадаг албан хаагчдад тогтмол өгч, хэвших, Нэгдсэн системд гарсан алдаа, зөрчлийг залруулах бол Цахим хүсэлтийн системд хүсэлтийг бүртгүүлдэг байх	Тус шүүх иргэний, эрүүгийн, зөрчлийн хэргийг дагнан шийдвэрлэдэг. Хэргийн ачаалаас шалтгаалан нэг шүүгчид дунджаар 1050 хэрэг оногдож байгаагаас үзэхэд 112,500 эрхийн акт тус шүүхэд албажсан байна. Үүнд шүүгч хугацаандаа эрхийн актыг гаргаагүйгээс 90 хувь нөлөөлсөн. Тамгын газар эрхийн актыг хугацаанд нь гаргах талаар 7 хоног бүр өнгөн хувийн дутууг гарган танилцуулсан. Тус шүүхийн хувьд нэгдсэн систем, Цахим цөм 2.0 системийг давхар ашиглан туршин нэвтрүүлэлт явуулж байгаа нь ачаалал 2 дахин нэмэгдсэн болохыг дурдах нь зүйтэй.	100
3	Шүүхийн шийдвэрийн цахим санд хяналт тавих: Шүүхийн шийдвэрийн цахим санд байршуулбал зохих шүүхийн шийдвэрийг байршуулж, хууль, дүрэм журамд нийцүүлэн шүүхийн шийдвэрт дурдсан хүн, хуулийн этгээдийн нэр, регистрийн болон улсын бүртгэлийн дугаар, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг мэдээллийг тодорхойлох боломжгүй болгон нууцлах	Тус шүүхийн хэмжээнд иргэний хэргийн нийт 7564 шийдвэр, эрүүгийн хэргийн нийт 870 шийтгэх, цагаатгах тогтоол гарсан байна. Үүнээс эрүүгийн хэргийн албажсан 764, иргэний хэргийн албажсан 5877 шүүхийн шийдвэрийг холбогдох журмын 5.1, 5.2-т заасан хугацаанд цахимд хуудаст орхигдуулахгүй бүрэн оруулж байгаа долоо хоног бүрийн баасан гариг бүр шалган шүүгчийн туслахаар гарын үсэг зуруулан шүүгч, ажилтны дотоод чат болон viber group чатад мэдээлж анхааруулж байна. Одоогоор дутуу шийдвэр байхгүй. Эрүүгийн хэргийн шүүхийн 764 шийдвэр, Иргэний хэргийн шүүхийн 5877 шийдвэрт дурдсан нийт 6531 хүн, 5886 хуулийн этгээдийн нэр, регистр, оршин суугаа болон үйл ажиллагаа явуулж байгаа газрын хаяг, эд хөрөнгийн бүртгэлийн дугаар зэрэг хүн, хуулийн этгээдийг тодорхойлох боломжтой мэдээллүүдийг бүрэн нууцлав.	100
4	Сүлжээний топологи: Байгууллагын дотоод сүлжээний топологи зураглал гаргах, биет буюу физик сүлжээний гэмтлээс хамгаалах, зохион байгуулалтыг сайжруулах	Тус шүүх нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр шинээр байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна. Байгууллагын дотоод сүлжээ, топологи зураглалыг Жавхлан хүслэн ХХК-иар гаргуулсан. Одоогоор сүлжээ, тоног төхөөрөмж бүгд шинээр хийгдсэн 3 жилийн баталгаатай.	100
5	Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, хүлээн авах, хуваарилах: Шүүхэд ирүүлсэн хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, нэгдсэн системд хуваарилахдаа журмын дагуу бүртгэж, шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажиллагаанд хяналтыг нэмэгдүүлэх	Тайлант онд тус шүүхэд эрүүгийн, зөрчлийн иргэний хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах, хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилж нарийвчилсан 3 журам батлагдсан байна. Системд орсон 3 удаагийн өөрчлөлт оруулах тохиргоог мэдээлэл технологи, лавлагаа, хэлтсийн дарга нарын хамтарсан баг гүйцэтгэж оруулав. Системийн тохиргоотой холбоотой гомдол хэн алинаас гараагүй. Хяналтыг хэлтсийн дарга нар 7 хоног бүр тавьж байна.	100
6	Хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол хуваарилахтай холбоотой шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын эх хувь, он цагийн дарааллаар системд тохируулж, өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулах	Тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дугаар тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 9/A дугаар тогтоолоор батлагдсан "Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, дүгнэлт, өргөдөл, гомдол, санал, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилж журмыг батлагдсан даруйд тохируулж, 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07/A зөвлөгөөний тогтоолоор эрүүгийн хэргийн танхимын 5 шүүгч иргэний хэргийн танхим руу шилжсэн тул бусад 15 шүүгчийн хэрэг нэхэмжлэлийг зогсоож, Шүүгчдийн зөвлөгөөний тогтоол, ерөнхий шүүгчийн захирамжаар чөлөөтэй, сургалттай шүүгчдийн хэрэг, нэхэмжлэл зогсоох, Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/A дугаар, 5 дугаар сарын 01-ний өдрийн 12/A дугаар тогтоолын холбогдох өөрчлөлтүүдийг системд тохируулан тус шүүхийн scp-court.mn цахим хуудсанд он цагийн дарааллаар байршуулсан.	100
7	Мэргэжилтэн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг системд байршуулахдаа хэлтсийн дарга, ерөнхий шүүгчийн туслахыг байлцуулан тохируулсан байх, энэ тухай тэмдэглэл үйлдэх	Тус шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 4 дүгээр тогтоол, 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 9/A дугаар тогтоол, "Шүүхэд хэрэг, нэхэмжлэл, дүгнэлт, өргөдөл, гомдол, санал, хүсэлт, хүлээн авах, хуваарилах, шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилж журам батлагдсаныг системд тохируулахдаа ерөнхий шүүгчийн туслах П.Туул, хэлтсийн дарга И.Энхцэцэг нарыг 2 удаа байлцуулан тохиргоо хийж, тэмдэглэл үйлдсэн. Тодруулбал: шүүгч чөлөөтэй, өвчтэй, сургалттай, ээлжийн амралттай, шүүгч тэтгэвэрт гарсан, сэлгэн ажиллах шүүгчийн зарлиг гарсан зэрэг тохиолдол бүрд өөрчлөлтийг тухай бүр системд тохируулан ажилласан.	100

8	Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программын ажиллагаа, програм дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг хийх (screen recording) бөгөөд программд хандсан хэрэглэгчийн эрх, үйлдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь хадгалагдаж, тэдгээрт хөндлөнгийн хяналт хийгдэх боломжтой байх	Тус шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилахад мэдээлэл лавлагааны мэргэжилтэн screen recording програм ашиглан програмд хандсан хэрэглэгчийн эрх, хийгдэж буй үйлдэл бүгд харагдах байдлаар дүрс бичлэгийг хийж байна. Одоогийн байдлаар Эрүүгийн хэргийн 1061 хэрэг, Иргэний хэргийн 32654 хэрэг, нэхэмжлэлийг хүлээн авч хуваарилсан бичлэгийг хийж архивлан хадгалж байна.	100
9	Дүрсний бичлэгийг 7 хоног бүр хадгалах төхөөрөмж /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/-д хуулбарлан, 1 жилийн хугацаанд хадгалж, түүнд Тамгын дарга тогтмол хяналт тавьж ажиллах	Тус шүүхэд хүлээн авсан эрүүгийн хэргийн 1061 хэрэг, иргэний хэргийн 32654 хэрэг, нэхэмжлэлийн нийт 2614 ширхэг 4.49ТВ бичлэг, мэдээлэл лавлагааны өрөөнд байрлуулсан хяналтын камерын 2461 ширхэг 3.16ТВ бичлэгийг долоо хоног бүрийн 5 дахь өдөр хард дискт хуулбарлан авч хадгалж байна. Тамгын газрын дарга долоо хоног бүр эрүүгийн болон иргэний хэргийн мэдээлэл лавлагааны ажилтан бичлэг явуулж байгаа эсэхэд хяналт, мэдээлэл технологийн мэргэжилтэн С.Ундармаа Баасан гариг бүр хард дискт хадгалж байна.	100
10	Шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг холбогдох байгууллага, иргэнд тухай бүр хүргүүлэхэд анхаарах. /Хууль, журамд заасан хугацаанд бүрэн гүйцэт, ойлгомжтой, гаргацтай бичиж хүргүүлдэггүйн улмаас эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн мэдээлэл цахим санд дутуу орж, ял завших нөхцөл үүсэж байна/	Тус шүүхийн Тамгын газрын даргын 2025 оны А/09 дугаар тушаалаар баталсан "Хяналт шалгалтын комисс" нь дотооддоо сар, 7 хоног тутам хяналт шалгалтыг явуулж уг хяналтыг шүүгч болон шүүгчдийн зөвлөгөөнд 28 танилцуулан ажиллаж байна. Үүнд: эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн бүртгэлийг хэлтсийн дарга хариуцан шүүгчийн туслахаас Баасан гариг бүр хугацаа болсон тэмдэглэлийг шаардан авч Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн лавлагааны санд /хугацаандаа/ хүргүүлж хүлээн авсан ажилтны гарын үсгийг тулган баталгаажуулж хэвшсэн, мөн мэдэгдэх хуудсыг дотооддоо https://scp-court.mn/judgex/login системд шивж оруулж бичиг хүргэгчид хүлээлгэн өгч үр дүнг системээр хянаж шүүхийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэн ажиллаж байна.	100
11	Хавтаст хэрэг илгээх, хүлээж авах журмын дагуу хэрэг, баримтыг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тавих хяналтыг нэмэгдүүлэх /Шүүхийн нэр, хэргийн оролцогчийн мэдээлэл, хавтаст хэргийн хуудасны тоо, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан огноо, эд мөрийн баримтын талаар тэмдэглэл үйлдэх ажиллагаанд анхаарах	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс баталсан 2022 оны 58 дугаар тогтоолоор "Хавтаст хэрэг илгээх, хүлээж авах журам"-д заасны дагуу шүүгчийн туслах журмын 2.2-т заасан ажиллагааг гүйцэтгэж, холбогдох ажилтан болох бичиг хүргэгчид хүлээлгэн өгч, бичиг хүргэгч шүүгчийн туслахаас журмын 2.3-т зааснаар хүлээн авч, зөвөөрлөн холбогдох шүүхэд хүргэх ажиллагааг хийж байна. Шүүхийн нэр, хэргийн оролцогчийн мэдээлэл, хавтаст хэргийн хуудасны тоо, хүлээлгэн өгсөн, хүлээн авсан огноог бүртгэж, эд мөрийн баримтын талаар тэмдэглэл үйлдэх ажиллагаанд анхаарч, иргэний болон эрүүгийн илгээж байгаа хэргийг системээр шилжүүлсэн эсэхийг тогтмол шалгаж, шүүгчийн туслах болон мэдээлэл лавлагааны ажилтанд мэдэгдэж, системээр шилжүүлэх ажиллагааг дор бүр нь хийж, хүлээлгэн өгөхдөө шүүгчийн туслах явуулсан бичгийн дэвтэрт, бичиг хүргэгч бичиг хүлээн авсан дэвтэрт, шуудангаар хүргүүлсэн тохиолдолд бичиг хүргэгчийн дэвтэрт бичилтийг тогтмол хийж байгаа эсэхийг шалгаж, эд мөрийн баримтыг албан тоотонд дурдаж, хэрэг буцаагдсан тохиолдолд шүүгчийн туслахад яаралтай алдааг залруулж хүргүүлэхийг даалгаж ажиллаж байна. Мөн бусад шүүхээс шилжин ирсэн, давж заалдах болон хяналтын шатны шүүхээс хянагдаж ирсэн хэргийг журмын 4.3-т заасны дагуу хүлээн авч, хүлээн авсан дэвтэрт бүртгэл хийж, хэргийн ард хүлээн авсан он,сар, өдөр, хуваарилагдах шүүгчийн нэрийг бичиж дардас дарж, шүүгчийн туслахад хүлээлгэн өгсөн болон системд бүртгэсэн эсэхэд болон журмын 4.4-т зааснаар бусад шүүхээс ирсэн богц, цоожийг ажлын гурван хоногийн дотор хүргүүлж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллаж байна. Тус шүүх нь эхний хагас жилийн байдлаар Иргэний танхимаас ижил шатны шүүх рүү хүргүүлсэн 83, давж заалдах шатны шүүх рүү хүргүүлсэн 247, ижил шатны шүүхээс хүлээлгэн авсан 110, давж заалдах шатны шүүхээс шийдвэрлэж буцаан хүргүүлсэн 181, Эрүүгийн танхимаас давж заалдах шатны шүүхэд хүргүүлсэн хялбарын 16, зөрчлийн 83, холбогдох цагдаагийн хэлтэс рүү нэмэлт ажиллагаа хийлгэхээр хүргүүлсэн 1124, давж заалдах шатны шүүхээс хялбарын 15, зөрчлийн 69 хэрэг хянан шийдвэрлэж буцаан хүргүүлсэн байна.	100
Гурав.Хэргийн хөдөлгөөний удирдлага, статистикийн чиглэлээр			
1	Хэрэг, нэхэмжлэл, хүсэлт, гомдол хуваарилахтай холбоотой шүүгчдийн зөвлөгөөний тогтоолын эх хувь, он цагийн дарааллаар системд тохируулж, өөрийн шүүхийн цахим хуудаст байршуулах	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Шүүгчдийн зөвлөгөөний 2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дугаартай 2025 онд хүлээж авах хэрэг, гомдол, хүсэлтийн хуваарилалт, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаан даргалагчийн дараалал тогтоох тухай" зөвлөгөөний тогтоол, "Хэрэг, гомдол, хүсэлт хүлээн авах, хуваарилах болон хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг сугалаагаар томилох нарийвчилсан журмыг нэгдсэн системд зөрчилгүй тохируулсан байна, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6/А дугаартай Шүүгчдийн зөвлөгөөнөөр шинээр Ерөнхийлөгчийн зарлиг гарч томилогдож ирсэн 7 шүүгчийг хэргийн хөдөлгөөний нэгдсэн системд нэмж сугалааны дараалалд оруулсан, 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 07/А дугаартай Шүүгчдийн зөвлөгөөнөөр Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх 5 таван шүүгчийг Эрүүгийн хэргийн нэгдсэн бүртгэл хяналтын системээс хасаж Иргэний хэргийн бүртгэл хяналтын системд нэмж оруулсан, зөрчилгүй. 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 09/А дугаартай Шүүгчдийн зөвлөгөөнөөр Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэдэг шүүгч Ц.Урангуа, С.Олзод, Э.Оюунтунгалаг нарыг Эрүүгийн хэргийн нэгдсэн бүртгэл хяналтын системээс хасаж Иргэний хэргийн бүртгэл хяналтын системд нэмж оруулсан, зөрчилгүй. Мөн Иргэний хэргийг хянан шийдвэрлэдэг шүүгч Б.Бямбаабаатар, Э.Энхтүвшин нарыг иргэний хэргийн нэгдсэн бүртгэл хяналтын системд идэвхгүй төлөвт оруулж, Эрүүгийн хэргийн бүртгэл хяналтын системд идэвхтэй төлөвт оруулсан. 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/А тогтоолоор өөрчлөлт оруулсныг системд тухай бүр өөрчлөлт, тохиргоог хийж, журмыг мөрдөн ажиллаж байна. Мөн тус тогтоолыг шүүхийн цахим хуудсанд он цагийн дарааллаар байршуулсан.	100

2	Мэргэжилтэн шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг системд байршуулахдаа хэлтсийн дарга, ерөнхий шүүгчийн туслахыг байлцуулан тохируулсан байх, энэ тухай тэмдэглэл үйлдэх	2025 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 04 дугаар, 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 6/A дугаар, 2025 оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн 09/A дугаар, 2025 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 11/A дугаар шүүгчдийн зөвлөгөөний тогтоолуудын хэрэгжилтийг хангах хүрээнд мэдээлэл технологийн мэргэжилтэн нь системд тохиргоо хийж байршуулахдаа хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга Т.Цэрэнчимэд, И.Энхцэцэг, Ж.Баттулга, Ерөнхий шүүгчийн туслах П.Туул, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн С.Цэрэндулам, З.Уугансүрэн нарыг байлцуулан тэмдэглэл үйлдэж баримтжуулан 4 удаа тохиргоо хийсэн байна.	100
3	Хэрэг, нэхэмжлэл, өргөдөл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилах, хэрэг хянан шийдвэрлэх шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг томилох программын ажиллагаа, программ дээр хийгдсэн үйлдэл бүрийг дүрс бичлэг хийх (screen recording) бөгөөд программд хандсан хэрэглэгчийн эрх, үйлдлийн дэлгэрэнгүй мэдээлэл, бүртгэл нь хадгалагдаж, тэдгээрт хөндлөнгийн хяналт хийгдэх боломжтой байх	Тус шүүхэд ирсэн хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлт, даалгавар хүлээн авах, хуваарилахад мэдээлэл лавлагааны мэргэжилтэн screen recording програм ашиглан програмд хандсан хэрэглэгчийн эрх, хийгдэж буй үйлдэл бүгд харагдах байдлаар дүрс бичлэгийг хийж байна. Одоогийн байдлаар Эрүүгийн хэргийн 1061 хэрэг, Иргэний хэргийн 32654 хэрэг, нэхэмжлэлийг хүлээн авч хуваарилсан бичлэгийг хийж архивлан хадгалж байна. Хяналтыг тамгын газрын дарга 7 хоног бүр бүртгэлээр тавьж, мэдээлэл технологийн мэргэжилтэн Баасан гариг бүр бичлэгийг хард дискт хадгалж байна.	100
4	Дүрсний бичлэгийг 7 хоног бүр хадгалах төхөөрөмж /CD, DVD, флаш диск, хард диск гэх мэт/-д хуулбарлан, 1 жилийн хугацаанд хадгалж, түүнд Тамгын дарга тогтмол хяналт тавьж ажиллах	Тус шүүхэд хүлээн авсан Эрүүгийн хэргийн 1061 хэрэг, Иргэний хэргийн 32654 хэрэг, нэхэмжлэлийн нийт 2614 ширхэг 4.49ТВ бичлэг, мэдээлэл лавлагааны ерөөнд байрлуулсан хяналтын камерын 2461 ширхэг 3.16ТВ бичлэгийн долоо хоног бүрийн 5 дахь өдөр хард дискт хуулбарлан авч хадгалж байна. Тамгын дарга долоо хоног бүр хяналт тавьж чиглэл өгч ажиллаж байна.	100
5	Шүүхийн шийдвэр, шүүхийн мэдэгдэх хуудас, гүйцэтгэх хуудас, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тухай тэмдэглэлийг холбогдох байгууллага, иргэнд тухай бүр хүргүүлэхэд анхаарах	Тайлант онд Эрүүгийн хэргийн 920 хүн, 1 хуулийн этгээдийн шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсноос 908 хүн, 1 хуулийн этгээдийн эрүүгийн хариуцлага хүлээсэн хүн, хуулийн этгээдийн тэмдэглэлийг Цагдаагийн Ерөнхий газрын мэдээлэл, дүн шинжилгээ шуурхай удирдлагын албаны статистик мэдээллийн хэлтсийн лавлагааны санд хүргүүлэв. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт эрүүгийн болон зөрчлийн, иргэний хэргийн шийдвэр хүчин төгөлдөр болон эрүүгийн хэргийн 940, зөрчлийн хэргийн 328, иргэний хэргийн 4791 гүйцэтгэх хуудас хүргүүлж, иргэний хэргийн оролцогч нарт 25858 мэдэгдэх хуудас хүргүүлэн ажилласан байна.	100
6	Хавтаст хэрэг илгээх, хүлээж авах журмын дагуу хэрэг, баримтыг шүүх хооронд илгээх, шилжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тавих хяналтыг нэмэгдүүлэх	Тус шүүх эрүүгийн 99, иргэний 330 хэргийг Нийслэл болон орон нутгийн шүүх рүү хүргүүлсэн байна. Хэргийг хүргүүлэхдээ зориулалтын богц ашиглан хэрэг хүлээн авах, хүргүүлэх ажилтнаар, шүүхийн тээврийн хэрэгслийн хамт хүргэх ажиллагаа явуулж байна. Шүүхээс хүргүүлсэн 430 хэрэг журмын дагуу хүргэгдсэн, дутуу хэрэг байхгүй.	100
7	Хэргийн хөдөлгөөний удирдлагын чиглэлээр хууль, дүрэм, журам, аргачлалуудаар дотоод сургалтыг зохион байгуулж, Хэргийн хөдөлгөөний хяналтын журамд заасан дотоод хяналт шалгалтыг сар бүр хийж, улирал бүр тайланг тогтоосон хугацаанд ирүүлдэг байх	Тус шүүхийн Тамгын газраас хэргийн хөдөлгөөний чиглэлээр буюу Улсын дээд шүүхтэй хамтран 2025.02.05-ны өдөр Иргэний хэргийн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт /32/ Тусгайланс журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сэдвээр, 2025.02.10-ны өдөр Иргэн, эрүүгийн хэргийн хөдөлгөөний нийтлэг аргачлалд орсон өөрчлөлтийн талаар хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга Т.Цэрэнчимэд, Ж.Баттулга, И.Энхцэцэг нар шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэргэжилтэн /47/ нарт, 2025.02.25-ны өдөр Иргэний хэргийн шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга /51/ нарт Иргэний хэргийн системийн ажиллагаа, хурлын тов, тоймыг цахим системд байршуулахад анхаарах асуудал сэдвээр иргэний хэргийн шүүгч Ч.Мөнхцэцэг, хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга Ж.Баттулга, 2025.04.24-ний өдөр тусгайланс журмын аргачлал, хэрэглээ, ойлголт сэдвээр Иргэний хэргийн шүүгч Т.Болормаа шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт /32/, 2025.08.11-д Тусгайланс журмаар хянан шийдвэрлэх иргэний хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээ, зөрчлийн хэргийн хөдөлгөөний түр аргачлалын журам батлагдсантай холбогдуулан хэргийн хөдөлгөөний хэлтсийн дарга Т.Цэрэнчимэд, мэргэжилтэн, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга нарт /37/ тус тус сургалт зохион байгууллаа. Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 158 дугаар тогтоолын дагуу Тамгын газрын даргын 2025 оны А/09 дугаар тушаалаар байгуулагдсан Дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсэг шалгалтыг сар зохион байгуулан шүүгчийн туслахын сейф дэх үзлэг, ажиллагаа, бичиг баримтын эмх цэгцгийг шалгаж дүнг Шүүгчдийн зөвлөгөөнөөр танилцуулав.	100
8	Шүүн таслах ажиллагааны статистик мэдээг улирал, хагас, бүтэн жилээр үнэн зөв гаргаж, Шүүхийн ерөнхий зөвлөлд тогтоосон хугацаанд хүргүүлэхэд анхаарах	Шүүн таслах ажиллагааны мэдээг батлагдсан маягтын дагуу эрүүгийн хэргийн төрөл, насны ангилал, хохирлын хэмжээ, таслан сэргийлэх арга хэмжээний төрлөөр, ялын төрөл тус бүрээр, иргэний хүлээн авсан хэрэг нэхэмжлэл, нэхэмжлэлийн төрөл, шийдвэрлэсэн, шийдвэрийн төрөл, татгалзсан, ажиллагаанд байгаа төрөл тус бүрээр, зөрчлийн хэргийн баривчилгаа, торгуулийн үзүүлэлт тус бүрээр улирал, хагас жилийн байдлаар гаргаж тогтоосон хугацаанд Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэн ажилласан. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар Иргэний 35593 хэрэг нэхэмжлэл хүлээн авч, 2159 татгалзаж, 12418 шийдвэрлэж, 6352 хэрэгсэхгүйгээр шийдвэрлэн ажилласан байна. Эрүүгийн 897 хэрэг хүлээн авч 800 хэргийг хянан шийдвэрлэсэн, Зөрчлийн 20590 хэргийг хүлээн авч, 16686 хэргийг шийдвэрлэсэн, Таслан сэргийлэх арга хэмжээний санал 2594 хүлээн авч шийдвэрлэсэн байна. Мэдээ тайланг хугацаанд нь Шүүхийн ерөнхий зөвлөлд сар, улирал, хагас жилээр хүргүүлсэн. Одоогоор мэдээнд алдаа зөрчил гараагүй байна.	100

9	Шүүх хуралдааны бэлтгэлийг хангах, шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр цахим систем /www.live.shuukh.mn/-д байршуулж, хяналтыг нэмэгдүүлэх: - Шүүх хуралдааны тов, тоймыг бүрэн бүртгэх; - Шүүх хуралдааны явцын мэдээллийг нарийн бичгийн даргаас бүрэн бүртгэдэг байх	Тус шүүхийн хэмжээнд тайлант хугацаанд Эрүүгийн 942, Зөрчлийн 16686, Иргэний 3169 шүүх хуралдааны бэлтгэлийг хангаж ажилласан. Шүүх хуралдааны тов, тоймыг тухай бүр цахим системд Эрүүгийн 503, Иргэний 3169 шүүх хуралдааны зарыг /www.live.shuukh.mn/-д мэдээлэл лавлагааны мэргэжилтэн байршуулан бүрэн бүртгэж шүүх хурлаар хэлэлцэгдэн шийдвэрлэхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга /www.live.shuukh.mn/ системийг хааж хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга 7 хоног бүрийн 5 дахь өдөр хяналт тавьж хаагаагүй нарийн бичгийн дарга нараар системийг хаалгаж хяналт тавьж байна. Нийт 20655 шүүх хуралдааны явцыг бүрэн оруулсан зөрчилгүй. Шүүгчийн туслах шүүх хуралдаан товлох болон шүүх хуралдааныг хойшлуулж дахин товлох үед тухайн хэргийн оролцогч өөр шүүх хуралдаантай эсэхийг /www.live.shuukh.mn/, /www.shuukh.mn/-сайтын шүүх хуралдааны зар хэсгээс шалгах, хэргийн оролцогчтой холбогдон товлох боломжтой эсэхийг тодруулсны эцэст боломжит хугацааг шүүгчид танилцуулж хэвшсэн байна.	100
10	Хэргийн оролцогчийг зайнаас буюу цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлыг холбогдох журмын дагуу зохион байгуулж, хяналтыг нэмэгдүүлэх. /Шүүгчийн туслах шүүх хуралдааныг цахимаар зохион байгуулах нөхцөл боломжийг судалж, тухайн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгч, шүүх бүрэлдэхүүнд мэдэгдэж, хэргийн оролцогчид 3 хоногийн өмнө мэдэгдэж байгаа эсэхэд анхаарах	Тус шүүх нь тайлант хугацаанд хэргийн оролцогчийг зайнаас буюу цахимаар шүүх хуралдаанд оролцуулах ажлыг эрчимтэй явуулж эрүүгийн хэргийн танхимын 21 шүүгчийг цахимаар шүүх хуралдаан явуулах нөхцөлийг бүрдүүлж, шүүгч тус бүрд камер, зоом эрх, нэмэлтээр 4 зөвлөлдөх тасалгааг шүүх хуралдааны цахим танхим болгон засварлаж, давхардсан тоогоор 15891 шүүх хуралдааныг /улсын яллагч, эрх бүхий албан тушаалтан, өмгөөлөгч, хэргийн оролцогч/ цахимаар явуулж шүүхийн ачаалал, оролцогч нарын ачааллыг зохицуулав.	100
Дөрөв. Шүүгчийн сонгон шалгаруулалт, хүний нөөцийн чиглэлээр			
1	Шүүгч шинээр томилогдсоноос хойш 7 хоногийн дотор төрийн алба хаасан хугацааг тодорхойлж, нэмэгдлийн хувийг тогтоолгох тухай албан бичиг, шүүгчийн нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагааг холбогдох баримтын хамт ирүүлдэг байх	Тус шүүх нь 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр байгуулагдаж 1 дүгээр сарын 07-ны өдрийн 24 дугаар албан бичгээр шүүгч нарийн төрийн алба хаасан хугацааг тодорхойлж нэмэгдэл хувийг тогтоох тухай албан бичгээр холбогдох баримтын бүрэн хүргүүлж, 41 шүүгч төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 1-25 хувийн нэмэгдэл авч байна.	100
2	Шүүгчийн шинээр томилогдсон тохиолдолд Шүүгчийн хувийн хэрэг хөтлөх журамд заасны дагуу 14 хоногийн дотор шүүгчийн хувийн хэргийг бүрдүүлэн эх хувиар ирүүлдэг байх	Тус шүүхэд ажиллаж байгаа 41 шүүгчийн хувийн хэрэг Шүүхийн ерөнхий зөвлөлд хадгалагдаж байгаа бөгөөд 2025 оны байдлаар шинээр шүүгч томилогдоогүй байна.	100
3	Шүүгчийн хүний нөөцтэй холбоотой мэдээллийг шүүгчийн хүний нөөцийн системд шуурхай оруулж, баяжилтыг хийдэг байх	Шүүгчийн хүний нөөцтэй холбоотой 13 шүүгчийн гэр бүлд хүүхэд мэндэлсэн, шагнал, урамшуулал, ажил эрхлэлтийн байдлын мэдээллийг тайлант онд бүрэн оруулсан. Түүнчлэн системийн мэдээллийг шүүгчид танилцуулж тулгалтыг 2025 оны 6 дугаар сарын 20-ны өдөр явуулсан.	100
4	Шүүхийн хүний нөөцийн систем шинэчлэгдэж, шүүгчийн хүний нөөц, хараат бус байдал, сонгон шалгаруулалтын цогц систем ашиглалтад орсонтой холбоотойгоор шинэ системийг ашиглах, уг системийг ашиглах талаар шүүгчдийг мэдээллээр хангах	Шүүхийн хүний нөөцийн системд эрх олгох ажлыг 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр өгч тус шүүхийн 41 шүүгчийг бүртгэлд оруулав. Тус системийн 3 цэсэд шинэчлэлт хийж бүртгэлжүүлэв. Систем хөтлөх, ирц бүртгүүлэх сургалтыг 2025 оны 6 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Систем засан сайжруулах нэмэлт оруулах 8 саналыг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэв.	100
5	Урт хугацааны чөлөөг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс авах бөгөөд уг хугацаанд чөлөө авсан үндэслэл арилагагүй, үргэлжлүүлэн чөлөө авах тохиолдолд чөлөөний хугацаа дуусахаас 14-өөс доошгүй хоногийн өмнө Шүүхийн ерөнхий зөвлөлд хүсэлтээ гаргах	Шүүгчийн урт хугацааны чөлөөг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр шийдвэрлэдэг бөгөөд уг хугацаанд чөлөө авсан үндэслэл арилагагүй, үргэлжлүүлэн чөлөө авсан тохиолдол гараагүй байна.	100
6	Чөлөө авсан тухайн мэдээллийг сар бүр shuugch-hr@judcouncil.mn цахим хаягт илгээдэг байх	Шүүгчийн чөлөөний судалгааг гарган shuugch-hr@judcouncil.mn 1-9 дүгээр сарын судалгааг тус хаягаар илгээсэн. Тайлант онд 29 шүүгчид 1-8 хоногийн чөлөөг өвчтэй, ар гэрийн гачигдал, сургалтад хамрагдах шалтгаанаар авсан байна.	100
7	Шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрсэн тохиолдолд тэтгэвэр тогтоолгох өдрөөс 120-оос доошгүй хоногийн өмнө мэдэгдэж, үүний дагуу тухайн орон тоонд 90-ээс доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалт зарлах хуулийн зохицуулалттай болохыг анхаарч ажиллах	3 Доржнамжин шүүгч өндөр насны тэтгэвэр тогтоолгох насанд хүрч тэтгэвэр тогтоолгосон байна. Түүнийг чөлөөлөгдөхөөс 90-ээс доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалт зарлуулах хүсэлтийг Ерөнхий шүүгчийн албан бичгээр хүргүүлж 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн 158 тогтоолоор зарласан байна.	100
8	Шүүгчтэй холбоотой тогтоол, шийдвэрийг танилцуулдаг байх	Тус шүүхийн тамгын газар нь шүүгчийн хүчингүй болсон 23, өөрчлөлт орсон 15 хэргийн магадлалыг шүүгч тус бүрд танилцуулав. Эрүүгийн болон иргэний хэргийн танхимын тэргүүн Шүүгчдийн зөвлөгөөн товлон тус шийдвэрийн талаар нэг мөр ойлгох чиглэлээр 2025 оны 5 дугаар сарын 15-ны өдөр, 2025 оны 7 дугаар сарын 23-ны өдөр, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдөр зөвлөлдөв.	100
9	Нийт шүүгчийн 3 дугаар чуулганы хүрээнд шүүгчдэд мэдээлэл хүргэх, судалгаа гаргаж ирүүлэх, шүүгчдийн аюулгүй байдлыг ханган чуулганд оролцуулахад шуурхай, хариуцлагатай хандаж, Ажлын хэсэгтэй нягт хамтран ажиллах.	Нийт шүүгчийн 3 дугаар чуулганы ажлын хэсэгт тус шүүхийн шүүгч Х.Оюунжаргал багтаж, мэдээллийг шүүгч нарт шуурхай хүргэн ажилласан. Тамгын газар шүүгчдийн viber группт Улсын дээд шүүх, шүүхийн академиас ирүүлсэн мэдээллийг шуурхай хүргэж, аюулгүй байдлыг хангах хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр нийт 37 шүүгчийг Urban Stages маркийн автомашинаар хүргэв. Түүнчлэн шүүгчдэд мэдээлэл хүргэх, биечлэн болон цахимаар оролцох шүүгчдийн судалгааг гарган 2025 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн 1134 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	100
Тав.Шүүхийн захиргааны хүний нөөцийн чиглэлээр			

1	Төрийн жинхэнэ албан хаагчийн үүргийг түр орон гүйцэтгүүлэхдээ эрх зүйн байдлыг дордуулахгүй байх	Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх үндэслэл", 43 дугаар зүйл "Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам"-ыг үндэслэн түр орлон гүйцэтгүүлж байна. Тодруулбал хэргийн хөдөлгөөний хэлтсийн даргын сул орон тоог 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдөр зарлуулсан бөгөөд тус орон тоонд шүүгчийн туслах Д.Айсаулегээр түр орлон гүйцэтгүүлж байна.	100
2	Тушаал, шийдвэрийн үндэслэлд холбогдох хуулийн зүйл, заалтыг зөв баримталдаг байх	Тушаал, шийдвэрийг гаргахдаа холбогдох хууль тогтоомжийг нягтлан шалгаж холбогдох зөв хуулийн зүйл, заалтыг баримталдаг. Одоогийн байдлаар давхардсан тоогоор томилсон 21, чөлөөлсөн, түр чөлөөлсөн 38, шилжүүлсэн 24 албан хаагчийн тушаал, шийдвэр гаргаад байна. Тушаалыг захиргааны ерөнхий хуульд заасны дагуу захираганы шийдвэрийн төсөл боловсруулах загварын дагуу боловсруулж тамгын газрын дарга хянаж баталгаажуулж байна.	100
3	Туршилтаар ажиллуулах хугацаа дууссан тохиолдолд ажлын үр дүнг үнэлж дүгнэн, үргэлжлүүлэн ажиллуулах эсэх асуудлыг тухай бүр шийдвэрлэдэг байх	Тус шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан 2 удаагийн сонгон шалгаруулалтаар 15 албан хаагчтай хөдөлмөрийн гэрээг үндсэн ажилтнаар, 1 албан хаагчийг 3 сарын хугацаанд туршилтаар сэтгэл зүйчийг ажиллуулж байгаа бөгөөд туршилтын хугацаа одоогоор дуусаагүй байна.	100
4	Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлөөс нэр дэвшүүлж, санал болгосон иргэнийг байгууллагадаа хүлээн авах шинэ соёлыг нэвтрүүлэх, тухайн албан тушаалд томилж, ажлын байранд сургаж, дадлагуулах, дасан зохицох нөхцөлийг бүрдүүлж ажиллах	Тус шүүхийн тамгын газар нь 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 56 дугаар албан бичгээр, 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 375 дугаар албан бичгээр, 2025 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 978 дугаар албан бичгээр, 2025 оны 9 дүгээр сарын 03-ны өдрийн 1267 дугаар албан бичгээр сонгон шалгаруулалт явуулах захиалгыг хүргүүлж, хэргийн хөдөлгөөн удирдлагын хэлтсийн даргын 1, зохион байгуулалтын хэлтсийн даргын 1, шүүгчийн туслахын 1, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын 8, мэдээлэл лавлагааны мэргэжилтний 1, мэдээллийн технологийн мэргэжилтний 1, орон тоонд нөхөн бүрдүүлэлт хийсэн байна. Төрийн албаны зөвлөлийн Шүүхийн ерөнхий зөвлөлийн дэргэдэх салбар зөвлөлөөс нэр дэвшүүлэх тогтоол ирэхээс өмнө тухайн шүүхэд ажилтныг дуудан ирүүлж, 7 хоногийн хугацаанд дадлагуулан сургаж, шүүхийн үйл ажиллагааг танилцуулан шүүгч Ч.Мөнхцэцэг, Ж.Лхагвасүрэн нараар сургалт оруулав. Шүүхэд ажиллахын ач холбогдлын талаар ахмад шүүгч С.Базархандтай уулзалт явуулсан.	100
5	Төрийн жинхэнэ албан хаагчийг сэлгэн ажиллуулж байгаа байгууллага түүнийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр дахин өөр төрийн байгууллагад үргэлжлүүлэн сэлгэн ажиллуулж болохгүй	Одоогийн байдлаар тус шүүхэд төрийн жинхэнэ албан хаагч сэлгэн ажиллаагүй байна.	100
6	Тухайн байгууллагын нэгж хооронд шилжүүлэн ажиллуулах тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчид өөрт нь мэдэгддэг байх	Тус шүүхийн тамгын газар нь төрийн жинхэнэ албан хаагчийг байгууллагын нэгж хооронд шилжүүлэн туслахаар М.Сарангэрэл, Б.Солонго, Ц.Цацрал, Б.Бадамсүрэн, М.Гантуяа, олон нийттэй харилцах мэргэжилтнээр Х.Наранбайгал, мэдээлэл лавлагааны мэргэжилтнээр Б.Ундармаа нарыг өөрт нь мэдэгдэн шилжүүлэн ажиллаж байна.	100
7	Хүний нөөцийг хууль, журамд нийцүүлэн зөв бүрдүүлэх, албан хаагчдын мэдлэг, чадвар, ёс зүй, ажлын хариуцлагыг дээшлүүлж, шүүхийн үйлчилгээг чанартай, чирэгдэлгүй хүргэхэд онцгой анхаарах	Тус шүүхийн тамгын газар нь сургалтын төлөвлөгөөний дагуу ёс зүй, мэдлэг үр чадварын сургалтыг 2025 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр "Төрийн захиргааны ёс зүйн дүрэм, хэргийн оролцогчтой зөв харилцаа үүсгэх, мэндлэх ёс, бие биеэ хүндлэх ёс, сахилга бат хариуцлага" сургагч багш ЗБХД И.Энхцэцэг удирдан, 2025 оны 2 дугаар сарын 24-ны өдөр тус шүүхийн шүүгч Ж.Лхагвасүрэн "Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр, Ч.Мөнхцэцэг шүүгч "Иргэний хэргийн Иргэн-2014 системийн заавар, хэрхэн ажиллах талаар тус тус сургалт орсон. 2025 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Улсын дээд шүүхийн Ахлах референт Н.Баяржаргал "Тусгайлсан журмаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр хэргийн хөдөлгөөний удирдлагын хэлтсийн дарга, иргэний шүүгчийн туслах, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн нарт, нарийн бичгийн дарга нарт сургалт зохион байгуулсан. Мөн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой гомдол мэдээллийг пэйж хуудсанд нээлттэй явуулж одоогоор ёс зүйн зөрчил гарган арга хэмжээ авсан албан хаагч байхгүй байна.	100
8	Холбогдох журамд заасан шаардлагыг бүрэн хангасан албан хаагчийн материалыг бүрэн бүрдэлтэй ирүүлж байх	Тус шүүхийн тамгын газар нь 2025 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 56 дугаар албан бичгээр, 2025 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 375 дугаар албан бичгээр, 025 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн 978 дугаар албан бичгээр, 9 дүгээр сарын 03-ны өдрийн 1267 дугаар албан бичгээр сонгон шалгаруулалт явуулах захиалгыг холбогдох материалын хамт бүрэн хүргүүлсэн.	100
9	Зэрэг дэв олгох, ахиулах болзол, шаардлагыг хангасан албан хаагчдын материалыг нэгтгэж, жилд 2 удаа ирүүлж байх; /07 дугаар сарын 01-10 болон 12 дугаар сарын 15-30 өдрийн хооронд/	Тус шүүхийн тамгын газар нь зэрэг дэв шинээр олгох, ахиулан олгуулахаар болзол, шаардлага хангасан албан хаагчийн материалыг 2025 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн 429 дугаар, 2025 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн 671 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Шүүхийн ерөнхий зөвлөлийн даргын 2025 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 85 дугаар тогтоолоор зэрэг дэв ахиулан олгохоор Г.Ганбаяр, Б.Золзаяа, Б.Баянжаргал, Г.Ганболор, Д.Ренчинханд, П.Туул, Д.Амуундарь, Б.Намуунзул, зэрэг дэв шинээр олгохоор Б.Нандинцэцэг, Т.Тунгалаг, Э.Энх-Учрал, С.Цэрэндулам, 2025 оны 9 дүгээр сарын 04-ны өдрийн 133 дугаар тогтоолоор зэрэг дэв ахиулан олгохоор Д.Мандахтуяа, А.Номин-Эрдэнэ нарын зэрэг дэв олгох тухай тогтоолыг үндэслэн зэрэг дэвийг олгосон байна.	100
10	Тухайн шагналын болзол, шаардлагыг бүрэн хангасан ажилтныг шагналд нэр дэвшүүлж, зураг, анкет, ажил байдлын тодорхойлолт зэрэг бүрдлийг бүрэн ирүүлж байх	Тус шүүхийн тамгын газар нь шагналын болзол, шаардлагыг бүрэн хангасан албан хаагчийн шагналд нэр дэвшүүлэх саналыг 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 62 дугаар албан бичгээр холбогдох материалын хамт хүргүүлж, Шүүхийн ерөнхий зөвлөлийн жуух бичгээр шүүгчийн туслах Ц.Отгонбаяр, Г.Ганбаяр нар шагнуулсан байна.	100
11	Хурлын тэмдэглэлийг шагнал тус бүр /төрийн дээд одон медаль/ дээр хавсаргаж ирүүлдэг байх.	2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 62 дугаар албан бичгээр төрийн дээд одон медальд нэр дэвшүүлэх шагналын материалын хамт тэмдэглэлийг хүргүүлсэн.	100
Зургаа. Санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын чиглэлээр			
1	Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэн, батлагдсан төсөв, орон тоонд багтаан, өр, авлага үүсгэхгүй ажиллах	2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөн батлагдсан төсвийн хүрээнд багтаан авлага, өр төлбөр үүсгэлгүй ажиллаж байна.	100

2	Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	Төрийн худалдааны авах ажиллагааны газарт 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдөр, 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн №22 цахим дэлгүүрт барааны нэр төрөл байршуулах тухай албан тоот тус тус явуулсан байна. Мөн тус шүүхийн тамгын газар нь хагас жилийн байдлаар тээвэр шатахуун, бичгийн цаас, албан бланк, принтерийн хор тус тус тендер зарласан байна.	100
3	Шилэн дансны нэгдсэн цахим санд мэдээллээ бүрэн, гүйцэт, үнэн зөв оруулах;	Шилэн дансыг сар бүрийн 08-ны дотор үнэн зөв ил тод нээлттэй байдлаар хөтлөн ажиллаж байна. Шилэн дансанд орхигдуулсан мэдээ байхгүй мөнгөн дүн 0.0 төгрөг. Нийт 2025 оны байдлаар 171 мэдээлэхээс хугацаандаа 131 мэдээллэсэн байна. 2025 оны 9 дүгээр сарын байдлаар шилэнд дансанд хоцорсон мэдээлэл байхгүй.	100
4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн анхан шатны хүчин төгөлдөр баримтаар ажил гүйлгээг бүртгэх	Анхан шатны баримтыг ажил гүйлгээ гарсныг нотолж бүрдүүлэлт хийж гэрээ, нэхэмжлэх, төлбөр төлсөн баримт болон бусад анхан шатны баримтыг бүрдүүлэн ажиллаж байна. 9 дүгээр сарын байдлаар харилцахын 9, бараа материалын 9 тус тус хийж гүйцэтгэсэн байна. Монгол Улсын Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн Аcoloux программыг үйл ажиллагаандаа ашиглаж өдөр бүрийн орлого зарлагыг аливаа эрсдэл гаргалгүй бүртгэж байна.	100
5	Сар бүр үндсэн хөрөнгө, эргэлтийн хөрөнгийн тайлан гаргаж, эд хариуцагчийн тооцоог актаар баталгаажуулж, хэвших;	2025 оны 9 дүгээр сарын байдлаар 1 шүүгч тэтгэвэрт гарч, 4 шүүгч, 6 захиргааны ажилтан өөр байгууллага руу шилжиж, 2 захиргааны ажилтан жирэмсний болон амаржсаны амралт эдэлж, 15 ажилтан ажлаас чөлөөлөгдсөнтэй холбоотойгоор эд хөрөнгөд тооллого хийж түүний ашиглалт, хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийж акт үйлдсэн.	100
6	Шатахууны тооцоонд норм, нормативыг баримтлах, жолоочийн тооцооны хуудас бичиж хэвших, эд хөрөнгийн тооллого хугацаанд нь хийх	Тамгын газрын жолооч О.Идэрсүрэн, Ж. Мөнхтөр, Н. Ронин нар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2024 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн 52 дугаар тогтоолын нэмэлт оруулах тухай хавсралтаар баталсан "Автомашини шатахуун зарцуулалтын норм тогтоосон хавсралтыг үндэслэн журам"-ын дагуу шатахуун зарцуулалтын нормыг сар бүрийн 05-ны өдрийн дотор тайлан гаргаж талоны дагуу тайлан бодогчтой тулгалт хийж хэвшсэн. Тодруулбал: хүйтний улирлын норм 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2 дугаар сарын 15-ны хооронд Hyundai Sonata-7 автомашин 16.8 литр, Hyundai starex автомашин 21.6 литр, Nissan urban автомашин 19.1 литр, Toyota harrier автомашин 20.4 литр бензин зарцуулдаг байна. Жолооч нар нь шатахуун зарцуулалтын нормыг хэтрүүлсэн тохиолдол байхгүй байна. Тус шүүхийн Тамгын газрын даргын А/29 тоот " Эд хөрөнгийн бүртгэл тооллого явуулах ажлын хэсэг томилох тухай" тушаалаар 2025 оны хагас жилийн эд хөрөнгийн тооллогыг 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг дуустал бүртгэл тооллогыг явуулж дууссан. 41 шүүгч, 42 шүүгчийн туслах, 41 нарийн бичгийн дарга, 59 албан хаагчдын эзэмшлийн эд хөрөнгийг тус бүрээр бүртгэн зурагжуулж, санхүүгийн программд оруулсан байна.	100
7	Төрийн албаны цалингийн нэгдсэн системээр бодсон цалин хөлсийг нийгмийн даатгалын тайлан, Хувь хүний орлогын албан татварын тайлангай тулгах	Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн цалин татвар, НД шимтгэл ногдуулалт тухайн сар бүрийн 30-ны дотор Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгал болон татварын газарт 9 удаа цалин хөлсний зөргүүг тайлагнаж ажиллаж байна. Татвар болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн илүү дутуу нь өглөг, авлага 9 дугаар сарын байдлаар гараагүй байна.	100
8	Улсын төсвөөс авсан санхүүжилт, нэмэлт санхүүжилтийг тулгаж, Төрийн сантай дансны үлдэгдлээ баталгаажуулах	Жилд 4 удаа 1,2,3,4 улиралд дансны үлдэгдлийн баталгаа гаргаж ажилладаг. 2025 оны 1, 2-р улиралд тус тус Сангийн ямаар 22,733,770.57 төгрөгийн дансны үлдэгдэл баталгаажуулсан байна.	100
9	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, актах болон бусад шийдвэрийг цаг алдалгүй эрх бүхий байгууллагаар гаргуулан, нягтлан бодох бүртгэлд тусгаж хэвших	2025 оны 07 дугаар сарын 30-ны №1089 тоот албан бичгээр балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалтыг ШЕЗ-ийн санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.	100
10	Барьцааны дансанд орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн бол батлагдсан журмын дагуу Төрийн санд тайланг хүргүүлж хэвших	Тус шүүхийн тамгын газарт барьцааны данс хамаарахгүй болно.	100
11	Ахмадын сангийн хөрөнгийг Ахмад настны тухай хууль, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын дагуу зарцуулж, Төсвийн тухай хуулийн дагуу тайлагнах	Тус шүүхийн тамгын газарт 2025 оны байдлаар Ахмадын сангийн төсөв төсөвлөгдөөгүй болно.	100
12	Харилцагч байгууллагуудтай авлага, өглөгийн тооцоо нийлж актаар баталгаажуулах	Тус шүүхийн тамгын газрын хагас жилийн санхүүгийн тайланд Монгол шуудан, Чингэлтэй дүүргийн нийгмийн даатгалын газар, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс, ТБ-дулаан Тахь Ко гэх газруудтай авлага өглөгийн тооцоо нийлсэн актаар баталгаажуулж хавсаргасан.	100
13	Төсвийн төлөвлөлтийг өмнөх оны батлагдсан төсвөөс өссөн, буурсан шалтгааныг үндэслэлтэй, зардлын эдийн засгийн ангилал бүрд тооцоо судалгаа хийсэн байх.	Тус шүүхийн тамгын газар нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн тул өмнөх оны батлагдсан төсвөөс өссөн буурсан шалтгааныг тооцох боломжгүй.	100
14	Орон нутгийн аудитын байгууллагад санхүүгийн тайланг хүргүүлэхээс өмнө Санхүү, хөрөнгө оруулалтын газраар хянуулах	Санхүүгийн тайланг 1,2,3,4-р улиралд Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэн ажиллаж байна. 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 484 дугаар тоотгоор 1-р улирлын санхүүгийн тайлан, 2025 оны 07 дугаар сарын 9-ны өдрийн 1028 албан тоотгоор хагас жилийн санхүүгийн тайланг тус тус хүргүүлсэн байна.	100
15	Нягтлан бодох бүртгэлийг НБББББичигт тулгуурлан тайлбарлах	Нягтлан бодох бүртгэлийг НБББББичигт тулгуурлан тайлбарлаж хэвшсэн.	100

16	Ажил гүйлгээтэй холбоотой тайлбарыг хууль, журмын хүрээнд тайлбарлах	Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын алба, анхан болон давж заалдах шатны шүүхийн тамгын газруудын нягтлан бодох үйл ажиллагааг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон төсвийн тухай хууль, холбогдох заавар, журамд бүрэн нийцүүлэн бүртгэл хөтөлж, мэдээллийг санхүүгийн бүртгэлийн программаар боловсруулсан.	100
17	Аудитаар санхүүгийн алдаа зөрчил гаргахгүй ажиллах, орон нутгийн аудитаас асуудал үүсгэвэл Санхүү хөрөнгө оруулалтын газраас мэргэжил, арга зүйн зөвлөгөө авч хамтран ажиллах	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дотоод аудитор П.Цолмонгоос мэргэжил арга зүйн зөвлөгөөг 2025 оны 2 дугаар сарын 10, 2025 оны 6 дугаар сарын 20, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрүүдэд авч хамтран ажиллаж байна	100
18	Аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг санхүүгийн тайланд хавсаргах	Тус шүүхийн тамгын газар 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа эхлүүлсэн тул аудитын зөвлөмж, төлбөрийн акт, албан шаардлага байхгүй болно.	100
19	Төсвийн тухай хуульд заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг уг гэрээний 3 дугаарт заасан үзүүлэлтээр нэг бүрчлэн гаргаж санхүүгийн тайланд хавсаргах	Үр дүнгийн гэрээний биелэлтийг хагас болон бүтэн жилийн санхүүгийн тайланд хавсарган Шүүхийн ерөнхий зөвлөлийн Санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлж, санхүүгийн тайланд хавсаргасан.	100
20	Сангийн сайдын 2012 оны 76 дугаар тушаалын дагуу төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэх	Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санхүү хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 1 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг 2 дугаар сарын 1 нд, 2 дугаар сарын мэдээг 3 дугаар сарын 1 нд, 4 дүгээр сарын мэдээг 5 дугаар сарын 1 нд, 5-р сарын мэдээг 6-р сарын 1нд, 6-р сарын мэдээг 7-р сарын 1нд, 8-р сарын мэдээг 9-р сарын 1нд, 9-р сарын мэдээг 10-р сарын 1нд тус тус илгээсэн. 1-9 дүгээр сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг үнэн зөв гаргаж, тус тус илгээсэн байна.	100
21	Шүүхийн төсвийг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журмыг хэрэгжүүлэх	Тус шүүхийн тамгын газар нь тухайн сард орсон зарцуулах эрхийг үндэслэн төлөвлөлт хийж сарын бүрийн 1-ны дотор зарцуулалтын тайлан гаргаж байна.	100
22	Зардлыг тооцож хуваарилахдаа тухайн жилд батлагдсан төсөв болон хэрэгжүүлэх зорилго, зорилт, арга хэмжээний хүрэх түвшинг нягт уялдуулахад анхаарах	Сар бүрийн төсөвт багтаан хуваарилахдаа батлагдсан төсөвт нягт уялдуулан зардлыг тооцож байна.	100
23	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг үндэслэлтэй тооцох	Тус шүүхийн тамгын газар нь зардлыг тооцохдоо төсөвчин болон бодит үнэ дээр тулгуурлаж санхүүжүүлэх эх үүсвэрийг үндэслэлтэй тооцон Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн санхүү хөрөнгө оруулалтыг газарт албан тоотой дамжуулан ажиллаж байна.	100
24	Байгууллагын батлагдсан төсөвт үндэслэн жил бүрийн эхэнд төсөвлөсөн санхүүгийн тайлан гаргаж хэвших	Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 1 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор Э-Тайлан нэгтгэлийн тайлан илгээж, харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн ажиллаж байна.	100
25	Төсвийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний төсөвлөсөн болон гүйцэтгэлээр өртгийг тооцоолдог байх	Тус шүүхийн тамгын газар нь сар бүрийн санхүүжилтийг зарцуулах эрхээр үндэслэн гүйцэтгэлээр өртгөө тооцож зарцуулалт хийж ажиллаж байна.	100
26	Шүүхийн барилгын газрыг шийдвэрлүүлэх, зураг төслийг хийлгэхдээ ШЕЗ-өөс шинэчлэн баталсан "Шүүхийн байрны стандарт"-ыг баримтлах	Тус шүүхийн 4 давхар барилга нь шүүхийн байрны стандартын дагуу зураг төсөл хийгдсэн байна.	100
Долоо. Үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах чиглэлээр:			
1	Иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн нөлөөллийн арга хэмжээг дотоод нөөц бололцоогоо ашиглан орон нутагт санаачлан зохион байгуулах;	Иргэдийн шүүхэд итгэх итгэлийг нэмэгдүүлэх, эрх зүйн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн нэхэмжлэл гаргах, 18 видео мэдээ болон гарын авлага, брошюрыг хэвлэн нийтлэх мөн жил болгон Монголын хуульчдын холбоо болон Монголын өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулагддаг про-бано өдөрлөгт тус шүүхийн зүгээс 2025 оны 5 дугаар сарын 01-ний өдөр болон 09 дүгээр сарын 20-ны өдрүүдэд идэвх санаачилга гарган оролцсон.	100
2	Шүүхэд итгэх иргэдийн итгэлийн түвшин үнэлэх судалгааг ШЕЗ-ийн судалгааны төвөөс боловсруулсан загвараар шүүхээр үйлчлүүлсэн болон шүүхээр үйлчлүүлээгүй иргэдийг хамруулан үнэн зөв бодитой судалгааг авч, улирал бүр судалгааг ШЕЗ-ийн Мэдээллийн төвд ирүүлэх	Шүүхээр үйлчлүүлж буй иргэдээс "Шүүхэд итгэх иргэдийн судалгаа"-г авч, улсын тэмдэгтийн хураамж, торгуулийн мөнгө төлөх арга механизмыг оновчтой байлгах, иргэдийг шүүхэд олон цагаар хүлээлгэхгүй байх, иргэдийг тогтмол мэдээллээр хангаж ажиллаж байна. Түүнчлэн иргэдээс цахим хаягаар жилд 2 удаа шүүхээр үйлчлүүлэхэд учирч буй хүндрэл, шүүхийн үйл ажиллагааны талаар QR код үүсгэн санал авсан. Тус саналыг нэгтгэвэл 1514 иргэнээс шүүхийн үйлчилгээ хэвийн, 138 иргэн шүүх хэргийг хугацаа хэтрүүлэн шийдвэрлэж байна гэсэн харуу өгсөн байна.	100
3	Шүүхийн Тамгын газрын цахим хуудасны бүтэц нь шүүхийн үйлчилгээг иргэд, олон нийтэд хүргэхэд чиглэсэн анхааруулах, зөвлөх, туслах шинжтэй байх	Тус шүүхийн тамгын газар тайлант онд шүүхийн scp-court.mn цахим хаягийг 2 удаа шинэчилж үндсэн цэс буюу эхлэл, шүүх, хэрэг хуваарилах журам, тамгын газар, иргэн танд, мэдээ, мэдээлэл, шийдвэрийн тойм, эвлэрүүлэн зуучлал, холбоо барих гэсэн 9 цэстэй. Нэхэмжлэлийн загварууд, Улсын тэмдэгтийн хураамж, Уулзах бичиг хүсэх, Зөрчлийн шийтгэвэр баримт, Шилэн данс гэсэн нэмэлт цэстэй. Иргэний хэрэг, Эрүүгийн хэрэг, Зөрчлийн хэргүүд гэсэн 3 хэсгүүдээс бүрдэх ба тус шүүхийн харьяалан шийдвэрлэх хэрэг маргаан болон иргэд, олон нийтэд шүүхийн үйлчилгээг илүү хялбар, бодит байдлаар авахад чиглэсэн. Шүүхийн цахим хуудасны иргэний хэрэг гэсэн цэсийг Улсын Дээд шүүхийн шүүгч Н.Баярмаад хянуулж, чиглэл авсан. Эрүүгийн, иргэний, зөрчлийн хэргийн шүүх хуралдааны товч иргэд тус цахим хуудаст хандан хүссэн үедээ харах боломжтой байдлаар шинэ систем нэвтрүүлсэн. Иргэний болон Зөрчлийн хэргийн оролцогчид өөрсдийн нэрээр хайлт хийж, ямар шүүгчид хуваарилагдсан болон холбогдох шүүгчийн туслахын утсыг харах боломжтой байдлаар цахим хуудсыг хөгжүүлэв.	100
4	Шинэ ажилтан, шүүгч томилогдсон, дотоод, гадаад сургалтад хамрагдсан бол заавал мэдээлдэг байх	2025 оны 7 дугаар сарын 07-ны өдөр тус шүүхийн тамгын газрын захиргааны албан хаагчид Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөсөн. Мөн тус шүүхийн тамгын газрын дарга О.Солонго Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын дэргэдэх "Олон улсын манлайллын төв" (COIL)-өөс хэрэгжүүлдэг "Нээлттэй дэлхий" хөтөлбөрт Монгол Улсаас сонгогдсон таван оролцогчийн нэг болж "Шүүхийн цахимжилт" сэдвийн хүрээнд Америкийн Нэгдсэн Улсад туршлага судлав зэрэг мэдээ мэдээллийг цаг тухай бүрт шинэчлэн сайт болон цахим хуудсанд байршуулав.	100

5	"Шүүхийн шийдвэрийг олон нийтэд мэдээлэх журам"-ын дагуу дата мэдээг өөрсдийн хийсэн ажилд үндэслэн тогтмол шинэчлэн ирүүлэх	Тус шүүхийн цахим хуудсан дахь Шүүхийн шийдвэрийн тойм цэсэнд шийдвэрийн болон процессын тоймыг ил харагдахуйц урсах байдлаар иргэдэд ойлгомжтой энгийн хэлбэрээр шинэчлэн байршуулсан. Иргэний хэргийн шийдвэрийн болон процессын тойм, эрүүгийн хэргийн шийдвэрийн болон процессын тойм, зөрчлийн хэрэг, таслан сэргийлэх арга хэмжээний тойм гэсэн нэмэлт цэстэй. Тус журмаар шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, бэжжүүлэх, шүүхийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг олон нийтэд ойлгуулах, иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, үнэн зөв мэдээллээр хангах зорилгоор шүүгч гаргасан шүүхийн шийдвэрийг энгийн, ойлгомжтой хэлбэрээр тоймлон тайлбарлах, шуурхай мэдээлэх, нийтлэх ажлыг ханган ажиллаж байна.	100
6	Нийт хэдэн шийдвэр, процессын тойм нийтэлсэн, үүнээс хэдийг нь шүүх өөрийн санаачилгаар, хэдийг нь сэтгүүлчийн хүсэлтээр нийтэлсэн болох, тухайн шүүхийн нийтэлсэн тоймыг ямар хэвлэлийн байгууллага нийтэлсэн болох, олны анхаарал татсан хэргийн тойм гарснаас хойш ташаа мэдээлэл гарсан зэрэг тохиолдлын талаарх мэдээллийг ирүүлж байх	Дүүргийн Эрүү, Иргэний хэргийн хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүх нь шүүхийн сайт болон цахим хуудсанд "Зөрчлийн хэргийн тойм"-7 ТСАХ-ний тойм-45 нийт 52 шийдвэрийн тойм байршуулсан. Олны анхаарал татсан шийдвэрийн тоймуудыг Шүүхийн шийдвэрийн тойм сайтад илгээн нийтэлсэн байна.	100
Найм. Шүүгчийн хараат бус байдал, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр:			
1	Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр гаргасан, эсхүл үйл ажиллагаа явуулсан, шүүгчийн эрх ашгийг зөрчсөн тохиолдолд уг шийдвэр, үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх, энэ талаар Ерөнхий зөвлөлд нэн даруй мэдэгдэж, тухайн асуудлын шийдвэрлэлтийн явцын мэдээллийг тогтмол мэдэгдэж ажиллах	Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан, алдагдуулсан шинжтэй шийдвэр, үйл ажиллагаа явагдаагүй.	100
2	Шүүгчийн хараат бус байдлыг хангах, хамгаалах чиглэлээр Хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд байршсан шүүх, шүүгчтэй холбоотой мэдээ, мэдээллийг бүртгэх, дүн шинжилгээ хийх, Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдэгдэх, шаардлагатай арга хэмжээ авхуулахаар эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлэх	Э.Тэмүүлэн, Ц.Санжаачойпэл, Л.Алтан-Очир нарт холбогдох ТСАХ-ний санал, Д.Саянжамбууд холбогдох ТСАХ-ний санал зэрэг тус шүүхэд шийдвэрлэгдсэн олны анхаарал татсан хэрэгтэй холбоотой Эрүүгийн хэргийн 2 шүүгчийн хэвлэл мэдээллийг хэрэгсэл, олон нийтийн сүлжээнд байршсан мэдээллүүдийг бүртгэн, Шүүхийн тамгын газарт мэдэгдсэн болно.	100
3	Шүүгчээс хөтөлсөн нөлөөллийн мэдүүлэг, тэмдэглэлийг холбогдох журамд заасны дагуу нууцлалыг хангаж, (баталгааны тэмдэг дарах) Шүүхийн ерөнхий зөвлөлд ирүүлэх	Тайлант онд шүүгчээс нөлөөллийн мэдүүлэг хөтлөөгүй байна.	100
4	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс хүргүүлсэн жишиг төлөвлөгөөний дагуу "Онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах төлөвлөгөө"-г цагдаагийн байгууллагатай журамд заасан хугацаанд хамтран батлах	Тус шүүхийн тамгын газар нь "Онцгой нөхцөл байдал үүссэн үед хамтран ажиллах төлөвлөгөө"-г цагдаагийн байгууллагатай журамд заасны дагуу төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батласан.	100
5	Шүүхийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээг холбогдох журам, аргачлалд заасны дагуу хийж, тайланг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлэх	Шүүхийн аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу 2025 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн А-32 дугаар тушаалаар эрсдлийн үнэлгээний багийг байгуулан эрсдлийн үнэлгээний тайлангийн төслийг 10 дугаар сарын 02-нд хүргүүлсэн.	100
6	Шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, шүүгдэгч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, шүүгдэгч, иргэний хэргийн хариуцагчийг эрэн сурвалжлах талаар хэрэгжүүлж байгаа ажилд хяналт тавих, шаардлагатай арга хэмжээ авах, энэ талаарх мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлд улирал тутам ирүүлэх	Тус шүүхэд тайлант онд иргэний хэрэгт 2153 хариуцагчийг албадан ирүүлэх, 53 зөрчилд холбогдогчийг эрэн сурвалжлах, 13 албадан ирүүлэх захирамж гарсан байна. Тамгын газар биелэлтийг хангах хүрээнд Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах хэлтсийн дарга Л.Баатар, цагдаагийн 8 алба хаагчтай 2025 оны 8 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулж, анхаарах асуудал, хэрэгжилтийн талаар санал солилцсон. Энэхүү ажлын хүрээнд албадан ирүүлэх, эрэн сурвалжлах ажиллагаанд хяналт тавих бүртгэлийн систем нэвтрүүлж үйл ажиллагаандаа ашиглаж байна. Цагдаагийн алба хаагчийн орон тоо хүрэлцээгүйгээс захирамжийн биелэлт хугацаа хоцорч буй хүндрэл гарсаар байна.	100
7	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хүрээнд шүүхийн Тамгын газрын эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж ажиллах;	Тус шүүхийн тамгын газрын эрх бүхий албан тушаалтнаар Д.Золжаргал ажиллаж байна. 10 дугаар сарын 08-ны байдлаар "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг 37 иргэнээр бөглүүлэн Авлигатай тэмцэх газарт хянуулж, "Хувийн ашиг сонирхлын хөрөнгө орлогын мэдүүлэг"-ийг 82 албан хаагчийн мэдүүлгийг авч бүртгэл хөтлөн ажилласан байна. Эрх бүхий албан тушаалтны хөтлөх 4 бүртгэлийг сар бүр, Авлигатай тэмцэх газрын хөрөнгө орлого, ХАСУМ системийн хөтлөлтийг шалгасан. Системийн хөтлөлт хэвийн, орхигдсон, илүү бүртгэгдсэн хүн байхгүй, бүртгэл балласан, засварласан алдаа байхгүй.	100
8	Шүүхийн тамгын газарт шинээр ажилтан томилохдоо холбогдох хууль, журамд зааснаар "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг заавал гаргуулж, томилох;	Тус шүүхийн тамгын газар нь шинээр болон байгууллагын нэгж хооронд ажилтан томилоход холбогдох хууль, журамд зааснаар "Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг"-ийг үүсгэн бөглүүлэн Авлигатай тэмцэх газарт хянуулан ашиг сонирхлын зөрчилгүй 10 ажилтанг томилон ажиллаж байна. Тайлант онд ХАСУМ мэдүүлээгүй томилгоо хийсэн ажилтан байхгүй байна.	100

9	Олны анхаарал татсан, олон оролцогчтой хэрэг, маргааны шүүх хуралдааны товыг Шүүхийн ерөнхий зөвлөлд урьдчилан мэдэгдэж, аюулгүй байдлыг хангах ажиллагааг цагдаагийн байгууллагатай хамтран шуурхай хэрэгжүүлж ажиллах	2025 оны байдлаар олны анхаарал татсан хэргийн 9 шүүх хуралдаан болох П.Цагаан, Ц.Элбэгдорж нарт холбогдох ТСАХ-ний санал, Б.Баярбаатарт холбогдох зөрчлийн хэрэг, ДуучинRookie/ буюу У.Мөнх-Эрдэнэд холбогдох зөрчлийн хэрэг, Монголын Эрчим хүч, геологи, уул уурхайн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга Д.Д-д холбогдох ТСАХ-ний санал, Г.Ганхуягт холбогдох ТСАХ-ний санал, Лайвчин Г.Солонгод холбогдох зөрчлийн хэрэг, Э.Тэмүүлэн, Ц.Санжаачойлэл,Л.Алтан-Очир нарт холбогдох ТСАХ-ний санал, Д.Саяннямбууд холбогдох ТСАХ-ний санал, МАН-ын нарын бичгийн дарга Ц.Чулуунзагдад холбогдох ТСАХ-ний санал зэрэг тус шүүхэд шийдвэрлэгдсэн олны анхаарал татсан хэрэгтэй холбоотой нарын тов, мэдээллийг Шүүхийн ерөнхий зөвлөлд урьдчилан мэдэгдэж ажилласан. Зөрчлийн хэргийн хувьд хэрэг шүүгчид хуваарилагдсан даруйд өдөртөө шийдвэрлэгддэг болно.	100
Ес.Архивын үйл ажиллагааны чиглэлээр:			
1	Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль журам, стандартад нийцүүлэх, сургалт зохион байгуулах;	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 214 дүгээр тогтоолоор батлагдсан "Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын хэрэгжилтийн талаарх сургалтыг Архивын ерөнхий газартай хамтран 2025 оны 1 дүгээр сарын 17-ны өдөр тус шүүхийн Тамгын газрын шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, мэдээлэл лавлагааны мэргэжилтэн, архивч /68/ албан хаагчдыг, 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн төрөлжсөн архивын дарга Ш.Отгонцэцэгт сургалт авах хүсэлт хүргүүлж, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр шүүхийн захиргааны 84 албан хаагчийг архив, албан хэрэг хөтлөлтийн ур чадвар олгох сургалтад хамруулав.	100
2	Зохион байгуулалтын нэгж, ажилтнаас архивын баримтыг хугацаанд нь бүрэн бүрдэлтэй авч хэвших, данс бүртгэлд хяналт тавих	Иргэний шийдсэн хэрэг шийдвэрлэсэнээс хойш 45 хоног, 117.1 хэрэгсэхгүй болгосон хэрэг 21 хоног, эрх зүйн акт буюу шүүхийн шийдвэр, ерөнхий шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, зөвлөгөөний тогтоол, шийтгэвэр тус тус 14 хоног, шүүгчийн захирамж 7 хоног тооцон авч байна. Данс бүртгэлийг тухай бүрд үйлдэж байна. 2025 оны 3 дугаар улирлын байдлаар шийдсэн 9926, хэрэгсэхгүй болгосон 5076 хэрэг, эрх зүйн актуудыг, мөн эрүүгийн 972 хэрэг хүлээн авч архив, албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу архивын баримт болгон данс бүртгэлд тусган 7 хоног бүр шүүгч, ажилтнаас шаардан авч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.	100
3	Байгууллагын архивын улсын үзлэгийн бэлтгэл хангах, архив зүйн стандартын ажиллагааг хэвшүүлэх	Байгууллагын архивын улсын үзлэгийн бэлтгэл ажлын хүрээнд шүүхийн Тамгын газраас хийх ажлын төлөвлөгөө боловсруулан ТГД-аар батлуулан хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. Уг ажлын хүрээнд Архивын ерөөнд стандартын шаардлага хангасан 6 нягтаршуулсан шүүгээ авч байршуулан дугаарлаж хадгаламжийн нэгжүүдийг хугацаа, төрлөөр төрөлжүүлэн байршуулсан бөгөөд тус өрөөг журмын дагуу тохижуулахад температур хэмжигч, ус чийгшил хэмжигч, галын хор, галын самбар, хүрз, элс, шаардлагатай багаж хэрэгслүүдийг авч стандартын дагуу бүрэн тохижуулсан. Мөн шаардлага хангасан архивын ерөөнд хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу архивт орсон иргэний 15002, эрүүгийн 561, зөрчлийн 16500 хэргүүд болон эрх зүйн актуудыг байршуулсан. Хууль зүй, дотоод хэргийн сайд, төв комиссын дарга Л.Мөнхбаатарын 2025 оны 8 дугаар сарын 28-ны өдөр баталсан Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтыг дүгнэх үзүүлэлт аргачлал, архивын улсын үзлэгийн төлөвлөгөөнд тусгагдсан 23 арга хэмжээг журмын дагуу гүйцэтгэж бэлтгэл ажлыг хангалаа. Үүнд: баримт бичиг зөв хөтлөх боловсруулах, хавсралтаар баталгаажуулсан байдал, ирсэн, явуулсан бичгийн хяналт, шийдвэрлэлт хяналт, хөтлөгдөж буй албан хэргийн хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу ангилан төрөлжүүлж, хэргийн дугаар өгч хөтөлсөн.	100
4	Архивын баримтын хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг холбогдох хууль журамд нийцүүлэх	Шүүхийн байрны 2, 3, 4 давхарт архивын өрөөг тохижуулан, архивын баримтын хадгалалт, хамгаалалтын стандартын дагуу зориулалтын нягтаршуулсан шүүгээ байршуулан, хаягжуулалтыг хийж, архивын баримтыг хөтлөх хэргийн нэрсийн жагсаалтын дагуу, он цагийн дарааллаар байршуулан бүрэн тохижуулсан.	100
5	Архив, бичиг хэргийн ажилтны ажлын байрны тогтвортой байдлыг хангах, архивчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн сургалтад хамруулах	2025 оны 4 дүгээр сарын 28-29-ны өдрүүдэд Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан Архивын ажилтнуудын сургалт, 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр архив, бичиг хэргийн ур чадвар олгох Шүүхийн ерөнхий зөвлөлийн төрөлжсөн архивын ажилтан н.Ууганзаяагаас сургалт авч бичиг хэргийн эрхлэгч 1, архивч 6, нийт 7 ажилтан хамрагдсан бөгөөд архивч тогтвортой ажиллаж байна.	100
6	Хадгалах хугацаа дууссан түр хадгалах баримтыг нягтлан шалгаж, жагсаалтыг харьяалах төрийн архивд хүргүүлэх	Тус шүүх нь 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулж байгаа тул одоогоор харьяалах төрийн архивд шилжүүлэх баримт байхгүй болно.	100
7	Шүүхийн архивын баримтыг цахимжуулах	Тайлант онд эрүүгийн шийдвэрлэсэн хэрэг 845 ширхэг, цахимжуулсан өнгөн хувь 21800 ширхэг, өнгөн хувь боть (Шүүгчийн захирамж-12, Шийтгэх цагаатгах тогтоол-14, Ерөнхий шүүгчийн захирамж-10, Шүүгчийн зөрчлийн захирамж-7, Зөрчлийн шийтгэвэр-13500), Иргэний шийдсэн хэрэг 2398 ширхэг, 117.1 хэрэгсэхгүй болгосон хэрэг 3228 ширхэг, өнгөн хувь 248 боть (шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж, зөвлөгөөний тогтоол, ерөнхий шүүгчийн захирамж) цахимжуулсан байна.	100
8	Архивын байрны аюулгүй байдлыг хангах, хяналт тавих, гамшгаас хамгаалах сургалт зохион байгуулах	Архивын байрны аюулгүй байдлыг хангах хүрээнд архивын 4 өрөөнд галын аюулгүй байдлыг хангах тоног, эд зүйлсийг байршуулан, өрөө тус бүрд нягтруулсан шүүгээ байрлуулав. 2025 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Чингэлтэй дүүргийн Онцгой байдлын газрын байцаагч Д.Наранцэцэгээс сургалт авч 6 архивчыг хамруулав.	100
9	Холбогдох журамд заасан тайлан мэдээг цаг хугацаанд нь ирүүлж хэвших	Архив дотоод ажлын болон архивын тооллогын хагас жилийн (6 дугаар сарын 25-ны дотор) мэдээ, тайлан маягт (13а, б)-ын дагуу гаргаж, тусгай архивд цахим болон албан бичгээр хүргүүлсэн. Архивын цахимжуулалтын тайланг сар бүрийн 25-нд тусгай архивт хугацаанд нь хүргүүлсэн. Тусгай архивын ажилд зайлшгүй шаардагдах судалгаа мэдээг тайлангын хугацаа харгалзахгүй гаргаж өгч хэвшсэн.	100
Арав. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас өгсөн үүрэг, зөвлөмжийг хэрэгжүүлэх чиглэлээр:			

1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний биелэлтийг хангуулах зорилгоор албан хаагчтай явцын ярилцлагыг улиралд 1-ээс доошгүй удаа зохион байгуулж, ярилцлагын явц, шийдвэрийн талаарх тэмдэглэл хөтлөх	Нэгжийн дарга нар сар бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Хяналтын хүрээнд нэгжийн дарга 2025 оны 4 дүгээр сарын 21-ний өдөр 85 албан хаагчтай явцын ярилцлагыг хийж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хангалтгүй хийсэн шүүгчийн туслах С.Энх-Амар, Д.Жавзандулам, Б.Баярбат нарт анхааруулга өгч, шүүгч Х.Санжидмаа, Ц.Наранчимэг, Э.Энхтүвшин нарт танилцуулан ажиллалаа.	100
2	•Албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн, халагдсан бол үнэлэх эрх бүхий албан тушаалтан тухайн өдрөөр гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлж, дуусгавар болгох	Тус шүүхийн тамгын газар нь 2025 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Н.Мөнгөнцэцэг 2025 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж түүнтэй уялдуулан нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулсан. Нэгжийн дарга нар 2025 оны 1 дүгээр сарын 10-ны өдөр 98 шүүхийн захиргааны ажилтантай гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулан ажилласнаас ажлаас чөлөөлөгдөж, шилжүүлсэн Д.Дуламсүрэн, Б.Батцэцэг, Т.Сарантуяа, Ж.Баттулга нарын төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж Өвөрхангай аймаг дахь шүүхийн тамгын газарт, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн тамгын газарт хувийн хэргийн хамт хүргүүлсэн. Мөн албан үүргээ хангалтгүй биелүүлсэн шүүгчийн туслах Б.Баярбатыг ажлаас халах тушаал гаргасан.	100
3	Хувь хүн /гэрээт ажилтан/-д олгож байгаа НДШ-д тооцогдох цалин хөлсийг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ данснаас гаргахгүй байх	Тус шүүхийн тамгын газарт 2025 оны 3-р улирлын байдлаар гэрээт ажилтан байхгүй байна.	100
4	Томилолтоор ажилласан шүүгч, албан хаагчдад хоол, унааны нөхөх төлбөрийг давхардуулан олгохгүй байх	Тус шүүхийн шүүгч, албан хаагчид 3-р улирлын байдлаар томилолт олгогдоогүй болно.	100
5	Албаны орон сууц эзэмшигчээр орон сууцыг даатгалд хамруулж, шимтгэл төлүүлэх ажлыг зохион байгуулах	Тус шүүхэд хамаарахгүй	100
6	Тамгын газрын албан хаагчдыг худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх онлайн сургалтад хамруулах, АЗ сертификаттай албан хаагчдын тоог нэмэгдүүлэх	Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтны эрхийг С.Эрдэнэзаяа, С.Энх-Амар, М.Бүрэнжаргал, А.Ариунзаяа, Э.Намуундарь нар авсан байна. Нийт ажилтны 3%-ийг эзэлж байна.	100
7	"Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам"-д заасны дагуу шүүхийн шийдвэр байршуулах сургалтыг зохион байгуулах	Шүүхийн тамгын газар нь Шүүхийн ерөнхий зөвлөлийн 2022 оны 39, 2024 оны 94 дугаар тогтоолоор баталсан "Шүүхийн шийдвэрийг цахим хуудаст байршуулах журам" болон журмын нэмэлт өөрчлөлтийг 2024 оны 4 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхэлсэнтэй холбоотойгоор шийдвэрийн цахим хуудсанд байршуулах, журамд орсон өөрчлөлтийн талаарх сургалтыг Шүүгчийн туслах, ШХНБД нарт хэлтсийн дарга нар 2025 оны 2 дугаар сарын 15, 8 дугаар сарын 20-ны өдрүүдэд зохион байгуулсан. Түүнчлэн шүүхийн шийдвэр хугацаандаа байршиж байгаа хяналтыг 7 хоног бүр гарган шүүгч, ажилтанд танилцуулан хугацаанд нь байршуулж байна.	100
8	Шүүхийн Тамгын газрын цахим хуудаст мэдээлэл бүрэн байршуулдаг байх;	Тус шүүх нь 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байгаа. Шүүхийн Тамгын газрын үйл ажиллагааны мэдээ, мэдээллийг өөрийн шүүхийн цахим хуудаст чанарын шаардлага хангасан хэлбэрээр тогтмол шинэчлэн scj-court.mn цахим хаягт байршуулдаг. Тамгын газрын 7 хоног, сар бүрийн мэдээг шүүхийн цахим хуудас болон нүүр хуудсанд тогтмол шинэчлэн нийтэлдэг. Шүүхийн цахим хуудсанд 215 мэдээлэл, нүүр хуудсанд 89 мэдээлэл байршуулсан байна.	100
9	Нэхэмжлэлийн загвар, бүрдүүлбэр, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн холбогдох заалт, торгууль, хураамж төлөх банкны дансны дугаар зэрэг мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбарт байршуулах	Монгол Улсын дээд шүүхээс баталсан "Тусгайлсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны нэхэмжлэлийн загвар"-ыг Word хэлбэрээр болон шууд татаж авах байдлаар видео гарын авлагыг бүтээн тус шүүхийн сайт болон пэйж хуудсанд, улсын тэмдэгтийн хураамж хэрхэн, хаана төлөх талаарх бичгийн болон видео зааврыг бүтээн иргэдэд хүргэсэн. Цахим хуудас болон нүүр хуудасны хандалтын тоо: 112500 байна. Түүнчлэн зөрчлийн хэргийн шийтгэврийн торгуулийн дансыг шүүхийн мэдээллийн самбар гадна болон дотор хэсэгт байршуулсан.	100